



**Харилцаа холбооны зохицуулах хорооны
2025 оны ээлжит 04 дүгээр хуралдааны
мэдээлэл**

Монгол Улсын Харилцаа холбооны зохицуулах хорооны 2025 оны ээлжит 04 дүгээр хуралдааныг 2025 оны 02 дугаар сарын 27-ны өдөр зохион байгуулав.

Харилцаа холбооны зохицуулах хорооны 2025 оны ээлжит 04 дүгээр хуралдаанаар /2025-02-27/ Радио, телевизийн хөтөлбөрт 2024 онд хийсэн мониторингийн нэгдсэн дүн, хэрэгжилтийн тайлан болон авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тухай танилцуулга; ХХЗХ-ноос 2024 онд цахим орчны зохицуулалтын талаар хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлангийн танилцуулга; Харилцаа холбооны зохицуулах хороонд 2024 онд ирүүлсэн өргөдөл, гомдол хүсэлтийн барагдуулалт, шийдвэрлэсэн тайлангийн танилцуулга; Харилцаа холбооны зохицуулах хорооны тусгай зөвшөөрлийн цахим системийн талаар танилцуулга; Хөрөнгө актлах, данснаас хасах тухай (Үүрэн холбооны нэр бүхий тоног төхөөрөмж); Тусгай зөвшөөрлийн тухай (Тусгай зөвшөөрөл шинээр олгох, зөвшөөрлийн хугацаа сунгах, нэмэлт оруулах, хүчингүй болгох тухай үнэлгээ, дүгнэлт; Харилцаа холбооны сүлжээний дугаар шинээр олгох, дугаарын ашиглалтын хугацааг сунгах тухай үнэлгээ, дүгнэлт; Бүртгэлийн гэрчилгээний хугацаа сунгах тухай үнэлгээ, дүгнэлт); Сонгон шалгаруулалт зохион байгуулах тухай (“Дараа үеийн хөдөлгөөнт холбооны 5 дахь үеийн (5G) системд радио давтамжийн зурвас ашиглах тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын баримт бичиг”); “ХХЗХ-ны хуралдааны дэг”-ийг шинэчлэн батлах тухай; бусад асуудал-Харилцаа холбооны зохицуулах зөвлөлийн даргаар ажиллаж байсан У.Тамирын өргөдөл, хүсэлтийн тухай зэрэг асуудлыг хэлэлцэн зохицуулах хорооны 16 (Тогтоол №242-257, 2025-02-27) тогтоолыг батлан шийдвэрлэсэн болно.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйл, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”, Харилцаа холбооны зохицуулах хорооны Өмч хамгаалах байнгын зөвлөлийн дүгнэлтийг тус тус үндэслэн 2025 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн 43 тоот “Үндсэн хөрөнгийг акталж данснаас хасах тухай” тогтоолыг батлав. Тогтоолд, хорооны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, энэхүү тогтоолын хавсралтад заасан 2 (хоёр) нэр төрлийн, нийт 298,657,717.08 (хоёр зуун ерэн найман сая зургаан зуун тавин долоон мянга долоон зуун арван долоон төгрөг найман мөнгө) төгрөгийн анхны өртөгтэй, 3,613,952.94 (гурван сая зургаан зуун арван гурван мянга есөн зуун тавин хоёр төгрөг ерэн дөрвөн мөнгө) төгрөгийн үлдэгдэл өртөгтэй үүрэн холбооны чанар шалгагч төхөөрөмжүүд нь үүрэн холбооны 5 дахь үеийн (5G) сүлжээний чанар, хамрах хүрээний хэмжилтийг хийх боломжгүй болсон тул акталж, ашиглалтаас хасах хүсэлтийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт тавьж шийдвэрлүүлэхийг даалгав.

Энэхүү хуралдаанаар Радио, телевизийн хөтөлбөрт 2024 онд хийсэн мониторингийн нэгдсэн дүн, хэрэгжилтийн тайлан болон авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тухай

танилцуулга; ХХЗХ-ноос 2024 онд цахим орчны зохицуулалтын талаар хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлангийн танилцуулга; Харилцаа холбооны зохицуулах хороонд 2024 онд ирүүлсэн өргөдөл, гомдол хүсэлтийн барагдуулалт, шийдвэрлэсэн тайлангийн танилцуулга; Харилцаа холбооны зохицуулах хорооны тусгай зөвшөөрлийн цахим системийн талаар танилцуулгыг тус тус сонсов. Радио, телевизийн хөтөлбөрт 2024 онд хийсэн мониторингийн нэгдсэн дүн, хэрэгжилтийн тайлан болон авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тухай танилцуулгыг хэлэлцээд, холбогдох бүтцийн нэгж (ӨНЗГ)-д мониторингийн үр дүнгээр цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг эрчимжүүлэх, хариуцлага тооцох хугацаатай үүрэг чиглэл өгч, Хорооны хуралдаанд 2025 оны 02 дугаар улиралд багтаан хэлэлцэхээр тогтов.

ХХЗХ-ны ээлжит 04 дүгээр хуралдаанаар Тусгай зөвшөөрөл шинээр олгох, зөвшөөрлийн хугацаа сунгах, нэмэлт оруулах, хүчингүй болгох тухай үнэлгээ, дүгнэлт; Харилцаа холбооны сүлжээний дугаар шинээр олгох, Харилцаа холбооны сүлжээний дугаарын ашиглалтын хугацааг сунгах тухай үнэлгээ, дүгнэлт; Бүртгэлийн гэрчилгээний хугацаа сунгах тухай үнэлгээ, дүгнэлт болон холбогдох газар, хэлтсийн боловсруулсан танилцуулга, үнэлгээний дүгнэлт бүхий 13 тогтоолын төслийг хавсралтын хамт тус тус хэлэлцээд, тус хуралдаанаас 13 тогтоолыг хавсралтын хамт батлан шийдвэрлэсэн. Үүнд:

- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 5.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, Шуудангийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн 2025 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн 43 тоот тогтоолыг баталж, тогтоолын хавсралтаар 1 хуулийн этгээдэд 1 тусгай зөвшөөрлийг (Дарцагт шанд ХХК: Улс хоорондын шуудангийн үйлчилгээ эрхлэх, Чиглэл: Монгол Улс-БНХАУ) шинээр олгосон;
- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 5.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийг тус тус үндэслэн 2025 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн 44 тоот тогтоолыг баталж, тогтоолын хавсралтаар 14 хуулийн этгээдэд 14 тусгай зөвшөөрлийг (Харилцаа холбооны сүлжээ, дэд бүтцийн суурилуулалт, засвар үйлчилгээ эрхлэх) шинээр олгосон;
- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 5.5 дугаар зүйлийн 10 дахь хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийг тус тус үндэслэн 2025 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн 45 тоот тогтоолыг баталж, тогтоолоор 1 хуулийн этгээдийн 1 тусгай зөвшөөрлийг (Монгол Улсын нутаг дэвсгэрт “Харилцаа холбооны сүлжээ, дэд бүтцийн суурилуулалт, засвар үйлчилгээ эрхлэх) сунгасан;
- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 5.5 дугаар зүйлийн 10 дахь хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийг тус тус үндэслэн 2025 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн 46 тоот тогтоолыг баталж, тогтоолоор 1 хуулийн этгээдийн 1 тусгай зөвшөөрлийг (Айрон товер ХХК: “Харилцаа холбооны сүлжээ байгуулах, түүний ашиглалт үйлчилгээ эрхлэх”) сунгасан;
- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 5.5 дугаар зүйлийн 10 дахь хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэг, 30 дугаар зүйлийн 30.1.10 дахь заалт, Радио долгионы тухай хуулийн 5¹ дүгээр зүйлийн 5¹.1.8 дахь заалтыг тус тус үндэслэн 2025 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн 47 тоот

- тогтоолыг баталж, тогтоолоор 1 хуулийн этгээдийн 1 тусгай зөвшөөрлийг (Тэргүүн медиа ХХК: “Арилжааны радиогийн үйлчилгээ эрхлэх”) сунгасан;
- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн 2025 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн 48 тоот тогтоолыг баталж, тогтоолоор 1 хуулийн этгээдийн 1 тусгай зөвшөөрлийг (Скайстрим ХХК: “Харилцаа холбооны сүлжээ байгуулах, түүний ашиглалт үйлчилгээ эрхлэх”) нэмэлт оруулсан;
 - Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 6.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, Шуудангийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4 дэх заалт, Эрчист гүрэн ХХК-ийн хүсэлтийг тус тус үндэслэн 2025 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн 49 тоот тогтоолыг баталж, уг тогтоолын хавсралтаар 1 хуулийн этгээдийн 1 тусгай зөвшөөрлийг (Эрчист гүрэн ХХК: Харилцаа холбооны сүлжээ байгуулах, түүний ашиглалт үйлчилгээ эрхлэх) хүчингүй болгосон;
 - Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 6.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, Шуудангийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4 дэх заалт, Юнайтед шиппинг ХХК-ийн хүсэлтийг тус тус үндэслэн 2025 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн 50 тоот тогтоолыг баталж, уг тогтоолын хавсралтаар 1 хуулийн этгээдийн 1 тусгай зөвшөөрлийг (Юнайтед шиппинг ХХК: “Улс хоорондын шуудангийн үйлчилгээ эрхлэх”) хүчингүй болгосон;
 - Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 6.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, Шуудангийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4 дэх заалт, Амар экспресс ХХК-ийн хүсэлтийг тус тус үндэслэн 2025 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн 51 тоот тогтоолыг баталж, уг тогтоолын хавсралтаар 1 хуулийн этгээдийн 1 тусгай зөвшөөрлийг (Амар экспресс ХХК: “Харилцаа холбооны сүлжээ байгуулах, түүний ашиглалт үйлчилгээ эрхлэх”, Дотоодын шуудангийн үйлчилгээ эрхлэх) хүчингүй болгосон;
 - Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.9 дэх заалт, Харилцаа холбооны сүлжээний дугаарын ашиглалт, үйлчилгээг бүртгэхтэй холбогдсон журмын 4.4 дэх хэсгийг тус тус үндэслэн 2025 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн 52 тоот тогтоолыг баталж, уг тогтоолын хавсралтаар 2 хуулийн этгээдэд 3 харилцаа холбооны сүлжээний дугаарыг шинээр (Альфа интележенс ХХК, Арван нэг арван нэг авто ХХК) 2 жилийн хугацаатай олгосон;
 - Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.9 дэх заалт, Харилцаа холбооны сүлжээний дугаарын ашиглалт, үйлчилгээг бүртгэхтэй холбогдсон журмын 4.4, 4.7, 4.8 дахь хэсгийг тус тус үндэслэн 2025 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн 53 тоот тогтоолыг баталж, уг тогтоолын хавсралтаар 3 хуулийн этгээдэд 3 серийн харилцаа холбооны сүлжээний дугаарыг шинээр (Онлайн нетворк ХХК, Юнител ХХК, Мобиком корпораци ХХК) олгосон;
 - Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.9 дэх заалт, Харилцаа холбооны сүлжээний дугаарын ашиглалт, үйлчилгээг бүртгэхтэй холбогдсон журмын 4.4 дэх хэсгийг тус тус үндэслэн 2025 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн 54 тоот тогтоолыг баталж, уг тогтоолын хавсралтаар 5 иргэн, хуулийн этгээдэд 5 харилцаа холбооны сүлжээний дугаарыг шинээр олгосон;
 - Харилцаа холбооны тухай хуулийн 12.3 дахь хэсэг, Домэйн нэрийг бүртгэх, ашиглах журмын 6.1.8 дахь заалтуудыг тус тус үндэслэн 2025 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн 55 тоот тогтоолыг баталж, уг тогтоолын хавсралтаар 3 хуулийн этгээдийн 3

MN болон MON өргөтгөлтэй домэйн нэрийн гэрээт бүртгэгчийн бүртгэлийн гэрчилгээний хугацааг 2 жилийн хугацаатай тус тус сунган шийдвэрлэв.

Харилцаа холбооны зохицуулах хорооны 2024 оны ээлжит 29 дүгээр хуралдаан, 2025 оны ээлжит 01 дүгээр хуралдаанаас өгсөн удирдамж, чиглэлийн дагуу “Харилцаа холбооны зохицуулах хорооны хуралдааны дэг”-ийг шинэчлэх төслийн танилцуулга, төслийг ХХНБ-ийн дарга, ЗУХАГ-аас боловсруулан хэлэлцүүлсэн. Тус хорооны дүрмийн 4 дүгээр зүйлийг үндэслэн “Харилцаа холбооны зохицуулах хорооны хуралдааны дэг”-ийг 2025 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн 56 тоот тогтоолын хавсралтаар шинэчлэн баталсан. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан тус хорооны 2023 оны 93 тоот тогтоол, 2024 оны 195 тоот тогтоолыг тус тус хүчингүй болгов.

Зөвшөөрлийн тухай хуулийн 5.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Радио долгионы тухай хуулийн 5¹ дүгээр зүйлийн 5^{1.1.2}, 5^{1.1.11} дэх заалт, Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын даргын 2020 оны А/45 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Монгол Улсад Дараа үеийн хөдөлгөөнт холбооны системийг нэвтрүүлэхэд баримтлах бодлогын чиглэл”, Цахим хөгжил харилцаа холбооны сайдын 2023 оны А/42 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Үндэсний радио давтамжийн хуваарилалтын хүснэгт”, Харилцаа холбооны зохицуулах хорооны 2023 оны 106 тоот тогтоолын хавсралтаар баталсан “Дараа үеийн хөдөлгөөнт холбооны системд ашиглах радио давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн нөхцөл, шаардлага”-ыг тус тус үндэслэн 2025 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн 57 тоот “Сонгон шалгаруулалт зохион байгуулах тухай” тогтоолыг хавсралтын хамт батлан шийдвэрлэв. Энэхүү тогтоолд, “Радио давтамжийн 3300-3400 МГц, 3500-4000 МГц-ийн зурвасыг Дараа үеийн хөдөлгөөнт холбооны 5 дахь үеийн системд ашиглах тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалт”-ыг 2025 оны 03 дугаар сарын 10-ны өдрөөс эхлэн зарлахаар шийдвэрлэв.

(Хуралдааны баталсан тогтоолын жагсаалт, холбогдох хавсралтыг <http://www.crc.gov.mn/main.php?cid=1&do=70&did=0> үзнэ үү).

Харилцаа холбооны зохицуулах хороо
2025-03-07